

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2023/149/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот  
2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул  
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn  
Аудитын менежер: И.Сэмжидмаа  
Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn  
Ахлах аудитор: Д.Нармандах  
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn  
Аудитор Ц.Төмөрсүх  
Утас: 9805-8805, Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....

  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....

5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.24 № 271

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бараа материалын тооллогыг хийгээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ" 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2. "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улчрал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

#### Аудитын гол асуудал

Аудитаар тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудал байна. Үүнд: Бараа материалын дансанд бүртгэлтэй 67.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй, баталгаажаагүй дүнг санхүүгийн тайланд тусгасан байна.

011020383

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2022 оны 12 -р сарын 31 өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	108,588,968.67	110,583,810.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	765,936.94	42,061,147.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	765,936.94	42,061,147.50
3121	Төгрөг	765,936.94	42,061,147.50
31211	Төрийн сангийн харилцах	765,936.94	42,061,147.50
33	АВЛАГА	54,580,100.00	800,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	54,526,200.00	-
335	Бусад авлага	53,900.00	800,000.00
3351	Байгууллагаас авах авлага	53,900.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	800,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	53,242,931.73	67,722,662.70
351	Түүхий эд материал	24,637,404.71	41,073,714.80
35110	Тусгай зориулалттай материал	5,127,622.90	5,127,622.90
35130	Эм боох материал	19,509,781.81	35,946,091.90
354	Хангамжийн материал	28,515,527.02	26,558,947.90
35410	Бичиг хэргийн материал	112,500.00	-
35420	Аж ахуйн материал	20,492,750.90	20,456,191.90
35440	Түлш, шатах тослох материал	2,520.12	-
35470	Бусад хангамжийн материал	7,907,756.00	6,102,756.00
35600	Мал амьтад	90,000.00	90,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	290,430,223.95	1,939,944,453.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	290,430,223.95	1,939,944,453.43
392	Биет хөрөнгө	286,514,223.95	1,936,028,453.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	38,423,580.64	1,617,770,819.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	(4,686,666.54)	(23,293,068.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	43,000,000.00	70,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(716,666.66)	(5,241,666.62)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	97,038,742.85	137,038,218.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	(42,061,504.07)	(56,275,010.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	104,188,100.00	172,322,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,555,302.83)	(43,003,084.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	96,655,612.00	96,655,612.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(18,771,671.44)	(29,945,466.64)
393	Биет бус хөрөнгө	3,916,000.00	3,916,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,916,000.00	3,916,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	399,019,192.62	2,050,528,263.63
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	399,019,192.62	2,050,528,263.63
51	Засгийн газрын хувь оролцоо	399,019,192.62	2,050,528,263.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	114,329,046.64	114,329,046.64
51101	Өмч: - төрийн	114,329,046.64	114,329,046.64
512	Хуримтлагдсан үр дүн	221,371,747.29	1,872,880,818.30
51210	Өмнөх үеийн үр дүн	64,921,313.13	221,371,747.29
51220	Тайлант үеийн үр дүн	156,450,434.16	1,651,509,071.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	63,318,398.69	63,318,398.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	399,019,192.62	2,050,528,263.63

**Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2022 оны 12 -р сарын 31 өдөр			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	854,526,935.71	2,261,716,144.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,021,495.71	1,719,827,514.21
120	Нийтлэг татварын бус орлого	86,021,495.71	1,719,827,514.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	86,021,495.71	5,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	86,021,495.71	1,714,327,514.21
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	64,854,557.56	1,693,977,514.21
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	21,166,938.15	20,350,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	768,505,440.00	541,888,630.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	371,968,800.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	371,968,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	357,860,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	303,233,800.00	-
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	54,526,200.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,439,890.00	25,600,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,439,890.00	25,600,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18,236,750.00	516,288,630.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,236,750.00	516,288,630.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	685,273,298.78	610,207,073.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	685,273,298.78	610,207,073.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	657,273,298.78	606,914,026.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310,389,779.59	361,889,683.44
210101	Үндсэн цалин	195,022,456.70	251,718,585.84
210102	Нэмэгдэл	68,417,627.56	71,378,948.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,155,999.41	5,132,997.60
210104	Урамшуулал	40,793,695.92	33,659,152.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,548,479.87	39,574,700.00
210201	Тэтгэврийн даатгал	27,535,401.21	27,021,409.26
210202	Тэтгэмжийн даатгал	2,929,200.00	3,166,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,343,500.00	2,532,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	521,854.05	633,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,218,524.61	6,221,290.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,332,350.60	19,562,353.01
210301	Гэрэл, цахилгаан	5,282,350.60	7,892,353.01
210302	Түлш, халаалт	4,750,000.00	11,400,000.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	270,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,692,750.00	25,592,479.12
210401	Бичиг хэрэг	2,337,500.00	3,328,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,736,640.00	15,602,520.12
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	592,900.00	819,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	809,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,525,710.00	5,033,259.00
2105	Нормативт зардал	152,657,682.65	74,116,077.91
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	118,775,332.65	51,512,589.91
210502	Хоол, хүнс	18,284,350.00	19,061,988.00

**Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,598,000.00	3,541,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,441,061.00	3,095,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,056,171.00	1,090,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,395,000.00	-
210604	Урсгал засвар	12,989,890.00	2,005,900.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	3,106,000.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	3,106,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	459,916.00	1,829,948.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	450,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	270,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,000.00	65,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,000,000.00
210807	Газрын төлбөр	9,916.00	44,748.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,751,279.07	78,146,884.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,300,000.00	13,180,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,451,279.07	64,966,484.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,000,000.00	3,293,046.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,000,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	3,293,046.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,293,046.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>169,253,636.93</u>	<u>1,651,509,071.01</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,803,186.77	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	12,803,186.77	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(12,803,186.77)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>156,450,450.16</u>	<u>1,651,509,071.01</u>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2022 оны 12 -р сарын 31 өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>713,979,240.00</u>	<u>601,914,830.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	5,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	5,500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	5,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	713,979,240.00	596,414,830.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	675,302,600.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	303,233,800.00	-
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	371,968,800.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,439,890.00	25,600,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,439,890.00	25,600,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18,236,750.00	570,814,830.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,236,750.00	570,814,830.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>713,213,303.06</u>	<u>560,619,619.44</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	713,213,303.06	560,619,619.44

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	685,213,303.06	557,326,572.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310,389,779.59	362,689,683.44
210101	Үндсэн цалин	195,022,456.70	252,518,585.84
210102	Нэмэгдэл	68,417,627.56	71,378,948.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,155,999.41	5,132,997.60
210104	Урамшуулал	40,793,695.92	33,659,152.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,548,495.87	39,574,700.00
210201	Тэтгэврийн даатгал	27,535,401.21	27,021,409.26
210202	Тэтгэмжийн даатгал	2,929,200.00	3,166,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,343,500.00	2,532,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	521,854.05	633,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,218,540.61	6,221,290.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,332,350.60	19,892,353.01
210301	Гэрэл, цахилгаан	5,282,350.60	7,892,353.01
210302	Түлш, халаалт	4,750,000.00	11,400,000.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,406,800.00	22,829,700.00
210401	Бичиг хэрэг	2,400,000.00	3,215,500.00
210402	Тээвэр, шатахуун	12,736,640.00	15,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	646,800.00	765,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,260,000.00	809,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,363,360.00	2,439,400.00
2105	Нормативт зардал	139,689,900.00	70,762,388.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,716,400.00	48,343,900.00
210502	Хоол, хүнс	17,475,500.00	18,876,988.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,498,000.00	3,541,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	124,086,061.00	26,281,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	51,096,171.00	20,183,200.00
210602	Тавилга	40,000,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	20,000,000.00	-
210604	Урсгал засвар	12,989,890.00	6,098,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	3,106,000.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	3,106,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	459,916.00	1,829,948.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	450,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	270,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,000.00	65,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,000,000.00
210807	Газрын төлбөр	9,916.00	44,748.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,300,000.00	10,360,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,300,000.00	10,360,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,000,000.00	3,293,046.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,000,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	3,293,046.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,293,046.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	765,936.94	41,295,210.56
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	765,936.94	41,295,210.56
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	765,936.94
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	765,936.94	42,061,147.50

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	64,921,313.13	242,568,758.46
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	64,921,313.13	242,568,758.46
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	156,450,434.16	156,450,434.16
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	221,371,747.29	399,019,192.62
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	221,371,747.29	399,019,192.62
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	221,371,747.29	399,019,192.62
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,651,509,071.01	1,651,509,071.01
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	1,872,880,818.30	2,050,528,263.63

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2022 оны 12 -р сарын 31 өдөр

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	573,438,500.00	557,326,573.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	573,438,500.00	557,326,573.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	573,438,500.00	557,326,573.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	369,925,500.00	362,689,684.44
210101	Үндсэн цалин	254,067,600.00	252,518,585.84
210102	Нэмэгдэл	72,177,700.00	71,378,948.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,297,600.00	5,132,998.60
210104	Урамшуулал	37,382,600.00	33,659,152.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,074,700.00	39,574,700.00
210201	Тэтгэврийн даатгал	28,410,800.00	27,021,409.26
210202	Тэтгэмжийн даатгал	3,166,000.00	3,166,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,532,800.00	2,532,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	633,200.00	633,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,331,900.00	6,221,290.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,600,000.00	19,892,353.01
210301	Гэрэл, цахилгаан	8,600,000.00	7,892,353.01
210302	Түлш, халаалт	11,400,000.00	11,400,000.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,829,700.00	22,829,700.00
210401	Бичиг хэрэг	3,200,000.00	3,215,500.00
210402	Тээвэр, шатахуун	15,600,000.00	15,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	765,300.00	765,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,825,000.00	809,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,439,400.00	2,439,400.00
2105	Нормативт зардал	71,485,400.00	70,762,388.00

**Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,343,900.00	48,343,900.00
210502	Хоол, хүнс	19,600,000.00	18,876,988.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,541,500.00	3,541,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,866,800.00	26,281,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,183,200.00	20,183,200.00
210604	Урсгал засвар	8,683,600.00	6,098,200.00
2107	Томилолт, зочны зардал	3,233,500.00	3,106,000.00
210702	Дотоод албан томилолт	3,233,500.00	3,106,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,268,000.00	1,829,948.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	450,000.00	450,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	382,500.00	270,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	141,500.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	119,000.00	65,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	114,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210807	Газрын төлбөр	60,500.00	44,748.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,154,900.00	10,360,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,154,900.00	10,360,400.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>573,438,500.00</b>	<b>598,621,783.01</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>25,600,000.00</b>	<b>22,306,953.01</b>
122005	Орон нутгийн төсвөөс	25,600,000.00	22,306,953.01
122	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>547,838,500.00</b>	<b>576,314,830.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	547,838,500.00	576,314,830.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	765,936.94
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	42,061,147.50

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төв нь эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг ард иргэдэд жигд хүртээмжтэй хүргэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүн амын амьдралын хэв маягийг өөрчлөх, зөв дадал зуршилд сургахад чиглэгдэнэ.

Зорилго: Тус Эрүүл мэндийн төв нь хүн амын эрүүл мэндийн хэрэгцээг хангасан нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг сумын болон харьяа сумын хүн амд ээлтэй тэгш хүргэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад оршино.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ард иргэдэд хүргэн үйлчилж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,651.5 сая төгрөгөөр буюу 413.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	765.9	42,061.1	41,295.2
Авлага	54,580.1	800.0	(53,780.1)
Бараа материал	53,242.9	67,722.7	14,479.7
Үндсэн хөрөнгө	290,430.2	1,939,944.5	1,649,514.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>399,019.2</b>	<b>2,050,528.3</b>	<b>1,651,509.1</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	399,019.2	2,050,528.3	1,651,509.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>399,019.2</b>	<b>2,050,528.3</b>	<b>1,651,509.1</b>

Мөнгөн хөрөнгийн данс 42.1 сая төгрөг болж 41.2 сая төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлээр санхүүжилттэй холбоотой зарцуулаагүй үлдэгдэл болно.

Авлагын үлдэгдэл 53.7 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 67.7 сая төгрөг болж 14.4 сая төгрөгөөр өссөн нь 48.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 34.4 сая төгрөгөөр буурсан бөгөөд эм боох материал 16.4 сая төгрөгөөр өсч, хангамжийн материал 2.0 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,939.9 сая төгрөг болж 1,649.5 сая төгрөгөөр өссөн нь 1,531.4 сая төгрөгийн өртөг бүхий эрүүл мэндийн төвийн барилга, 183.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн бол тайлант хугацаанд 19.2 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс 2,050. сая төгрөг болж 1,651.5 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 486.6 сая төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлогоос 61.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 547.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн зардлыг 535.0 сая төгрөгөөр буюу зардлыг 12.8 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсвийг 547.8 сая төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 547.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 58,6 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 516.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 25.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 53.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 535.0 сая төгрөг буюу 97.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Дашбалбар сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Нурболат, аудитор Ц.Төмөрсүх, хяналтыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор

Д.Нармандах, аудит менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 2 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 810.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажилласан байна.

Тухайн байгууллагын батлагдсан орон тоон дээр дэд дарга, орлогчийн албан тушаалын ажилтан байхгүй байгаа бөгөөд авто тээврийн хэрэгсэл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ буюу төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйлд заасан авто тээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ, шаардлагатай байгууллага байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус байгууллага нь 2022 онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 129.9 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төв нь 1.9 сая төгрөгийн худалдан авалтын нэмэгдсэн өртгийн албан татварын цахим төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна. Энэ нь Нягтлан

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар батлагдсан өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэж заасныг зөрчсөн, хэрэгжүүлж ажиллаагүйд албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага хүргүүлснээс төлбөрийн актыг бүрэн барагдуулсан бол албан шаардлагын хувьд уг зөрчлийг арилгах боломжгүй байсан, 2022 онд уг алдааг давтан гаргахгүй ажилласан байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	0.6	1	0.6	100%
Албан шаардлага	2	381.0	2	381.0	100%
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>381.6</b>	<b>3</b>	<b>381.6</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдах авах гэрээ, тайланг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцэж байх эсэхийг үзэх.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 71.0 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 2.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 67.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, 0.8 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

#### 5.1 Төлбөрийн акт

Тайлант онд Ковид-19-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд ажилласан ажилтнуудад нэг удаагийн тэтгэмж болох нийт 24.0 сая төгрөгийг олгохдоо хувь хүний орлогын албан татвар суутгаагүй. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна.”, 14 дүгээр зүйлийн 14,1-д “Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна.” 7 дугаар зүйлийн 7.1-д “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна:”, 7.1.6-д “үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.2 Албан шаардлага

Бараа материалын дансанд бүртгэлтэй 67.7 сая төгрөгийн хөрөнгөд тооллого хийгээгүй, баталгаажаагүй дүнг санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

## 5.3 Зөвлөмж

**Илрүүлэлт:** 2022 оны жилийн байдлаар санхүүгийн тайланд тусгасан 0.8 сая төгрөгийн дансны авлагын үлдэгдэлд тооцоо нийлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Зөвлөмж:** Төсвийг зохистой удирдан авлага үүсгэхгүй байх, хувь хүнээс авах 0.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулах, түүнийг барагдуулан биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дансны авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй.	1	800.0					1	800.0				
Бараа материалын тооллого хийгээгүй байна.	1	67,722.7			1	67,722.7						
Ажилтнуудад олгосон нэг удаагийн тэтгэмжийн 24.0 сая төгрөгөөс хувь хүний орлогын албан татвар суутгаагүй	1	2,400.0	1	2,400.0								
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>70,922.7</b>	<b>1</b>	<b>2,400.0</b>	<b>1</b>	<b>67,722.7</b>	<b>1</b>	<b>800.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
2022 онд шилэн дансны мэдээллийг байршуулахдаа санхүүжилтийн дүнг /1сар/ мэдүүлээгүй.	1	34,533.5			1	34,533.5		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>34,533.5</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>34,533.5</b>	<b>0</b>	<b>-</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Тайлант онд Тулгат мандал ХХК байгууллагаас худалдан авалтын НӨАТ-ийн төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна	1	1,920.0			1	1,920.0		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,920.0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1,920.0</b>	<b>0</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>36,453.5</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>36,453.5</b>	<b>0</b>	<b>-</b>